



ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/414

Зуунмод


Мотоциклийн хөдөлгөөнийг түр
хугацаагаар хориглох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.11, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.10, 66 дугаар зүйлийн 66.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5, аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/635 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Зуунмод сумын нутаг дэвсгэрт замын хөдөлгөөнд оролцогчдын эрүүл мэнд, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, учирч болох хор хохирол, эрсдэлийг багасгах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах зорилгоор 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 01-нийг хүртэл хугацаанд мотоцикльтойгоор замын хөдөлгөөнд оролцохыг түр хугацаагаар хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль эрх зүйн мэргэжилтэн (Д.Амартүвшин)-д, илэрсэн зөрчлийг арилгуулах, ард иргэдэд замын хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай анхааруулга сэрэмжлүүлэг өгч, сурталчилах ажлыг зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга, Хэсгийн байцаагч нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.САРАНГЭРЭЛ